

**ЗАХИРГАА ИРГЭДИЙН
ХООРОНДЫН МАРГААНЫГ
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ НЬ**



ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ

Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны талаар гомдолтой байгаа иргэн, хуулийн этгээд нь захиргааны хууль бус актын улмаас зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд болон захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны маргааны гол зүйл нь зөвхөн захиргааны акт болдог.

ТАЙЛБАР

Дараахь байгууллагын зөвхөн гадагш дагаж мөрдөх буюу заавал биелүүлэх захиргааны акт нь захиргааны хэргийн шүүхэд хамаарна. Гадагш чиглэсэн гэдэг нь захиргааны байгууллага, албан тушаалтан өөрийн доод шатны байгууллага, албан тушаалтанд бус харин “гуравдагч” гэж хэлж болох иргэд, байгууллагад холбогдолтой буюу тэдгээрийн эрх ашиг сонирхлыг хөндсөн акт хамаарна.

1. Монгол Улсын Засгийн газрын гишүүн /Ерөнхий сайд, сайд/;
 2. Монгол Улсын яам;
 3. Монгол Улсын Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг;
 4. Төрийн албаны Зөвлөл, түүний салбар байгууллага;
 5. Монголбанк;
 6. Санхүүгийн зохицуулах хороо
-
7. Яамны харьяа болон харьяа бус захиргааны акт гаргадаг бие даасан агентлаг, түүнтэй адилтгах газар, зөвлөл, товчоо, төв, сан зэрэг байгууллага;
 8. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга;
 9. Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг /хэлтэс, газар/;
 10. Улсын хяналт шалгалтын болон захиргааны хяналтын байгууллага, тэдгээрийн хянан шалгагч, байцаагч, цагдаагийн, тагнуулын, хилийн цэргийн байгууллага, түүний захиргааны таслан зогсоох болон шийтгэлийн арга хэмжээ авах эрх бүхий бүх албан тушаалтан;
 11. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн нийтийн Хурал, тэдгээрийн Тэргүүлэгчид;
 12. Төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг болон холбоо, харилцаа, эрчим хүчний системийн захиргаа зэрэг үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг байгууллага;
 13. Сүм хийдийн захиргаа;
 14. Шийдвэр, үйл ажиллагааг нь захиргааны хэргийн шүүхэд давж гомдол гаргаж байхаар хуульд тусгайлан заасан нийтийн эрх зүйн субъект болох бусад байгууллага, албан тушаалтан.

Захиргааны акттай холбоотой
гомдол нэхэмжлэлийг хянан
шийдвэрлэх ажиллагааны
төрлүүд


Захиргааны хэрэг хянан
шийдвэрлэх ажиллагаа

Захиргааны хэрэг шүүхэд
хянан шийдвэрлэх
ажиллагаа

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 16-Р ЗҮЙЛИЙН 12-Р ЗААЛТ

Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ УРЬДЧИЛАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА НЬ ДАРААХЬ АГУУЛГАТАЙ



1. Нийтийн
захиргааны
байгууллагад
өөрийн
хяналтыг
хэрэгжүүлэх

2. Иргэдийн эрх,
хууль ёсны ашиг
сонирхолыг
захиргааны
хэргийг
хамгаалах

Гомдол-Захиргааны байгууллагын буруугаас иргэн, хуулийн этгээдийн эрх нь зөрчигдөж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр гаргасан хүсэлт

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ УРЬДЧИЛАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ДАРААЛАЛ


Захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа нь гомдлыг дээд шатны захиргааны байгууллагад гаргана

Эрх бүхий удирдах байгууллага
Жнь: Дүүргийн засаг даргыг шууд харьяалах дээд шатны захиргааны албан тушаалтан нь Нийслэлийн засаг дарга

ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД ГОМДОЛ ГАРГАХ ХУГАЦАА


Иргэн, хуулийн
этгээдээс гомдол
гаргах хугацааг 30
хоногийн дотор
байхаар тогтоодог

Зайлшгүй хүндэтгэн үзэх
шалтгаанаар хугацаа
хэтэрсэн бол хугацаа
хэтэрсэнээс хойш 3 сарын
дотор сэргээж болно




Гомдол гаргах
хугацаандаа
хүндэтгэн үзэх
шалтгаангүйгээр
гомдлоо гаргаагүй
бол эрхээ алдана

30 хоногийн дотор
хэргийг хянаад дараахь
шийдвэрийн аль
нэгийг гаргана




Захиргааны акт нь илт
хууль бус болохыг
хүлээн зөвшөөрөх



Захиргааны актыг
бүхэлд нь эсвэл
холбогдох хэсгийг
хүчингүй болгох



Дахин захиргааны акт
гаргахыг даалгах



ХЭРГИЙН ОРОЛЦОГЧИД

Гомдол гаргагч иргэн,
хуулийн этгээд

Хариуцагч болох
захиргааны байгууллага,
албан тушаалтан

Гуравдагч этгээд-Хууль
ёсны ашиг сонирхол нь
хөндөгдсөн иргэн, хуулийн
этгээд

НЭХЭМЖЛЭЛ

Иргэний хэргийн шүүхэд хандаж эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус баялагтай холбоотой маргаж байгаа буюу зөрчигдсөн эрх, ашиг сонирхлоо хамгаалахын тулд анхан шатны шүүхээр дамжуулан эрх зөрчигчид тавьж буй шаардлага юм.

ЗААВАР

Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүхэд

Нэхэмжлэл гаргах нь:

2015.04.16 Тосонцэнгэл сум

Нэхэмжлэгч: Боржигон овогт Батаагийн Батнасан Тосонцэнгэл сумын Оргих багторшин суух, регистрийн дугаар пю: 53121511 Утас: 99123456

"Ажиллаж байсан байдлаа тогтоолгох тухай"

Миний бие 1969 онд Завхан аймгийн Нөмрөг сумын 8 жилийн дунд сургуулийг төгсөж улмаар эвлэлийн илгээлтээр хөдөө гарч 1969 оны 6 дугаар сараас 1973 оны 4 дүгээр сар хүртэл Нөмрөг сумын Жаргалант нэгдэлд туслах малчинаар, 1973 оны 4 дүгээр сараас 1994 оны 12 дугаар сар хүртэл тус нэгдэлдээ малчинаар ажилласан. Миний анх ажилд орсон болон гарсан тушаал архиваас олдоогүй учир 1973 оны 4 дүгээр сараас 1994 оны 12 дугаар сар хүртэл улсад нийт 21 жил ажиллаж байсан байдлыг минь тогтоож өгнө үү.

ЗАХИРГААНЫ ХУУЛЬ БУС АКТЫН ТАЛААР ШҮҮХЭД ХАНДСАН НЭХЭМЖЛЭЛИЙН ШААРДЛАГА НЬ

- захиргааны акт, захиргааны гэрээг хүчингүй болгуулах, илт хууль бус болохыг тогтоолгох, эсхүл эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, захиргааны акт гаргуулахыг даалгах, нэхэмжлэлийн хувьд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн болохыг;
- хохирол гаргуулах нэхэмжлэлийн хувьд захиргааны байгууллага ямар үүргээ биелүүлээгүйгээс, эсхүл захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас нэхэмжлэгчид ямар хохирол учирсан, түүнийг хэрхэн шийдвэрлүүлэх талаар;
- нийтийн эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгох нэхэмжлэлийн хувьд эрх зүйн харилцаа байгаа эсэхийг тогтоолгосноор нэхэмжлэгчид ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол үүсэхийг;
- захиргааны байгууллагаас гаргах нэхэмжлэлийн хувьд ямар хууль зөрчигдсөн, эсхүл нийтийн эрх зүйн ямар чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрсэн;
- нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж байгаа этгээдийн хувьд маргаж байгаа асуудлын талаар хангалттай сонирхол илэрхийлсэн байх бөгөөд нийтийн ямар ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй;
- захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох нэхэмжлэлийн хувьд иргэн, хуулийн этгээдийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй болон ямар хуультай зөрчилдсөн.

ДАВЖ ЗААЛДАХ ХУГАЦАА



АНХАН ШАТНЫ
ШҮҮХИЙН
ШИЙДВЭРИЙГ ЭС
ЗӨВШӨӨРВӨЛ **14**
ХОНОГИЙН ДОТОР
ГОМДОЛ ГАРГАХ



ДАВЖ ЗААЛДАХ
ШҮҮХ **30**
ХОНОГИЙН
ДОТОР ХЯНАН
ШИЙДВЭРЛЭНЭ



ДАВЖ ЗААЛДАХ
ШҮҮХИЙН
МАГАДЛАЛЫГ
АВААД **14**
ХОНОГИЙН
ДОТОР ДЭЭД
ШҮҮХЭД ГОМДОЛ
ГАРГАХ ЭРХТЭЙ



УЛСЫН ДЭЭД
ШҮҮХ **30**
ХОНОГИЙН
ДОТОР ХЭРГИЙГ
ХЯНАН
ШИЙДВЭРЛЭНЭ



ДЭЭД ШҮҮХ
НИЙСЛЭЛД **3**
ХОНОГИЙН
ДОТОР, ОРОН
НУТАГТ **14**
ХОНОГТ УЛСЫН
ДЭЭД ШҮҮХЭД
ХҮРГҮҮЛНЭ

Улсын дээд шүүх
дараахь
байдлаар
тогтоол гаргана

Шийдвэр магадлалыг хэвээр үлдээж гомдлыг
хангахгүй орхих

Шийдвэр магадлалд өөрчлөлт оруулах

Магадлалыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь
хүчингүй хэвээр үлдээх, эсвэл өөрчлөх

Шийдвэр магадлалыг хүчингүй болгож, хэргийг
хэрэгсэхгүй болгох

Анхан шатны шүүхэд буцаах
